



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 06 өдөр

Дугаар A/393

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “а”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 3.2.6.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарлах тухай 06/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2018 оныг “Хүүхдийн хөгжил, хамгааллын жил” болгон зарласантай холбогдуулан зохион байгуулсан “Шилдэг анги удирдсан багш” шалгаруулах болзолт уралдааны тэргүүн байрт шалгарсан багш нарыг урамшуулах зорилгоор Тайвань улсад сургалтад хамруулах, мэргэжил дээшлүүлэхэд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Гадаад аялалд шаардагдах 9000000 (есөн сая) төгрөгийг үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаярт)-т зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100638

Аймгийн Засаг даргын 2019 оны 06
дүгээр сарын 06-ны өдрийн 4393 дугаар
захирамжийн хавсралт



**ШИЛДЭГ АНГИ УДИРДСАН БАГШ ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНД
ТЭРГҮҮН БАЙРУУДАД ШАЛГАРСАН БАГШ НАРЫН ШАГНАЛЫН
ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ /төгрөгөөр/
1	Шилдэг анги удирдсан багш шалгаруулах уралдааны тэргүүн байр /гадаад аялал/	5 багш	1,800,000	9,000,000
Нийт				9,000,000

-ооо-